



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/01/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 7052-2734

Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 7052-3020

Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа

Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.08.16 № 16/201

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Ц.НАРАНЗУЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	82.5	80.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,758.9	4,657.5
	Нийт хөрөнгийн дүн	4,841.4	4,737.8
	Нийт өр төлбөрийн дүн	10.0	0.5
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,831.4	4,737.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,841.4	4,737.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	667.3	661.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	760.8	754.1
	Үйл ажиллагааны үр дүн	(93.5)	(92.3)
	Үйл ажиллагааны бус үр дүн	0.2	0.3
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(93.7)	(92.6)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,476.6	5,476.6
	Хуримтлагдсан үр дүн	(645.2)	(739.4)
	Эцсийн үлдэгдэл	4,831.4	4,737.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	652.1	662.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	658.8	653.2
	Үйл ажиллагааны ЦМГ	(6.7)	9.2
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(5.7)	(9.2)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(12.3)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12.3	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийтлэг үйлчилгээний газрын эрхэм зорилго нь хэрэглэгчдэд чанар, стандартын түвшинд хүрсэн нийтлэг үйлчилгээг үзүүлэхэд оршино.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмч 100 хувь орон нутгийн өмч байна.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 499.4 сая төгрөгийн 12 орлогын гүйлгээ, 117.5 сая төгрөгийн 7 зарлагын гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 25.3 сая төгрөгийн 2 худалдан авалтын гүйлгээг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад нийт 15 мэдээллийг хугацаа хоцроосон, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 25.3 сая төгрөгийн худалдан авалтын 2 гүйлгээг мэдээлээгүй байна.

3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 2.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.2 сая төгрөгийн алдааг залруулж, 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 2.2 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- 2.2 сая төгрөгийн акталсан бараа материалыг үйл ажиллагааны зардлаар бүртгэснийг үйл ажиллагааны бус зардлаар бүртгэж залруулав.

5.2 Албан шаардлага

1. Тус байгууллагын шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад нийт 15 мэдээллийг хугацаа хоцроосон, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 25.3 сая төгрөгийн худалдан авалтын 2 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-т Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6 дугаар зүйлийн 6.4.5-т “...орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр...” тус тус мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. 2021 оны санхүүгийн тайланд 2.8 сая төгрөгийн авлагад тооцоог нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “ерөнхий нягтлан бодогч нь... дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог ... баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

